



ЗТХЯ-ны харьяа “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын
нэгдсэн төв” УТҮГ

**Хөдөлгөөн зохицуулалтын төвийн
ажилтнуудад зориулсан
”Гүйцэтгэлийн төлөвлөгөө,
тайлан боловсруулах арга зүй”
сэдэвт сургалт-танилцуулга**

Захиргаа, санхүүгийн хэлтэс

2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр



Хууль эрх зүйн орчин

1. Төрийн албаны тухай хууль
2. Хөдөлмөрийн тухай хууль
3. Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол
4. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол
5. Хөдөлмөрийн дотоод журам



Төрийн албаны тухай хууль

54 дүгээр зүйл. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө

54.1. **Төсвийн шууд захирагч** тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан **өөрийн эрхлэх асуудлын хүрээнд** хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор **гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж**, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд **хэрэгжүүлнэ.**



Хөдөлмөрийн тухай хууль

5 дугаар зүйл. Ажил олгогчийн эрх, үүрэг

5.2. Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй.



Хөдөлмөрийн тухай хууль

6 дугаар зүйл. Ажилтны эрх, үүрэг

6.2. **Ажилтан нь үнэнчээр хөдөлмөрлөх**, хуулиар тогтоосон нууцад хамаарах ажил, үүрэгтэй нь холбоотой нууцыг хадгалах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нийтлэг шаардлагыг сахин биелүүлэх **үүрэгтэй.**



Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга

42 дугаар зүйл. Ажилтны үндсэн эрх, үүрэг

42.2.1. ажил үүргээ биечлэн, үнэнчээр, өөрийн ур чадвар, боломжоо дайчлан зохих ёсоор гүйцэтгэх;

42.2.5. техник, технологийн горим баримтлах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн чиглэлээр ажил олгогчоос өгсөн үүрэг даалгаврыг мөрдөж ажиллах;



Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга

42 дугаар зүйл. Ажилтны үндсэн эрх, үүрэг

42.2.7.ажил олгогчийн удирдах чиг үүргээ хэрэгжүүлэх эрхэд хүндэтгэлтэй хандах, ажил олгогч, **ажил олгогчийн төлөөлөгчийн хууль ёсны үүрэг даалгаврыг цаг тухайд нь бүрэн биелүүлэх;**

42.2.9.ажил олгогчийн шаардсанаар ажил үүрэгтэй холбоотой **мэдээллийг ажил олгогчид үнэн зөвөөр өгөх, хийсэн ажлаа тайлагнах;**



Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга

43 дугаар зүйл. Ажил олгогчийн үндсэн эрх, үүрэг

43.1.2. **ажилтнаас хүлээсэн ажил үүргээ гүйцэтгэх, хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг дагаж мөрдөхийг шаардах;**



Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга

43 дугаар зүйл. Ажил олгогчийн үндсэн эрх, үүрэг

43.2.6. ажилтныг ажлаар хангаж, ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, баримт бичиг, бусад зүйлээр хангах, зааварчилгаа өгөх;



Засгийн газрын 2020 оны 216 дугаар ТОГТООЛ

Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийн хангах журмын 1.3.1-д “**Стратеги төлөвлөгөө**” гэж байгууллагын мандат, алсын хараа, эрхэм зорилго, орчны шинжилгээ, стратегийн зорилго, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, арга зам (стратеги)-ыг тодорхойлсон баримт бичгийг;



Засгийн газрын 2020 оны 217 дугаар ТОГТООЛ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 2.1-д **Төсвийн шууд захирагч** нь тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан **өөрийн эрхлэх асуудлын хүрээнд** хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор байгууллагын **гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж**, жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд **хэрэгжүүлнэ.**



Хөдөлмөрийн дотоод журам

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.3. **Нэгжийн дарга** албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд **нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, ажлын үр дүнг Захирлын өмнө бүрэн хариуцаж ажиллана.**



Хөдөлмөрийн дотоод журам

Дөрөв. Ажил олгогч, ажилтны эрх, үүрэг

4.4.Ажилтан дараах үүрэгтэй:

4.4.1.энэ журам болон төвийн хэмжээнд мөрдөх бусад дүрэм, журмыг сахин биелүүлэх, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэж, биелэлтийг хугацаанд нь эргэн танилцуулж, захирах, захирагдах зарчмыг баримтлах;



Хөдөлмөрийн дотоод журам

**Тав.Төлөвлөлт, тайлан гаргах, ажлын үр дүнг үнэлж,
дүгнэх**

5.1.Төлөвлөлт

5.1.3.төв нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж баталж, хэрэгжүүлнэ.



Хөдөлмөрийн дотоод журам

5.1.4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгана:

-хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн төвийн үйл ажиллагааны чиглэлд хамаарах зорилт, арга хэмжээ;

-төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас үүрэг болгож даалгасан болон төвийн дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ;



Хөдөлмөрийн дотоод журам

5.1.4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгана:

- ӨМНӨХ ОНЫ төлөвлөгөөгөөр биелээгүй, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ;
- ТӨВИЙН үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тухайн жилд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ;
- цаг үеийн зорилтыг биелүүлэх шаардлагын үүднээс тухайн жилд шинээр гүйцэтгэх арга хэмжээ;



Хөдөлмөрийн дотоод журам

5.1.5.нэгжүүд төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж чиг үүргийн дагуу жилээр төлөвлөгөө боловсруулж тухайн оны 01 дүгээр сард баталж, хэрэгжүүлнэ.

5.1.6.төвийн гүйцэтгэлийн болон нэгжийн жилийн төлөвлөгөөг үндэслэн нэгжүүд сар бүр төлөвлөгөө батлуулж ажиллана. Төлөвлөгөөг тайлант сарын 05-ны дотор батлуулна.



Хөдөлмөрийн дотоод журам

5.2.6.нэгж, ажилтнууд төвийн **гүйцэтгэлийн** болон нэгжийн жилийн **төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал, биелэлтийг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор гаргана.** Нэгжийн дарга нэгжийн жилийн төлөвлөгөөний, **холбогдох ажилтан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг Захиралд цахимаар танилцуулна.**



Нэр томъёоны тодорхойлолт

Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг
Суурь түвшин	Хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;
Зорилто т түвшин	Хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг



Гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвар

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуца х нэгж
Стратеги төлөвлөгөөний зорилго 1							
1.1	Арга хэмжээ						
1.2	Арга хэмжээ						
1.3	Арга хэмжээ						



Жишээ:

Шалгуур үзүүлэлт	Жишээ 1: Тайлангийн тоо 18 Жишээ 2: Боловсруулалтын явц, хувиар Жишээ 3: Сургалтад хамрагдах ажилтны тоо 12 Жишээ 4: Барилгын ажлын явц, хувиар
Суурь түвшин	Жишээ 1: Шинээр хэрэгжүүлнэ Жишээ 2: Судалгааны ажлыг эхлүүлсэн Жишээ 3: Төслийн төлөвлөлтийн судалгаа хийгдсэн Жишээ 4: Барилга угсралтын ажил 30 хувь
Зорилтот түвшин	Хоногийн 3840, долоо хоногийн 192, сарын 108, улирлын 80, жилийн 25 мэдээгээр нэгдсэн санг бүрдүүлж, ЗТХЯ, ҮСХ-г жилийн 25, улирлын 56, сарын 12 мэдээллээр хангана

ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНД
ТАВИГДАХ НИЙТЛЭГ
ШААРДЛАГА

Зорилт нь үр
дүнд
суурилсан,
бодитой,
биелэгдэхүйц

Хэрэгжүүлэх
арга
хэмжээнүүд
нь зорилтдоо
чиглэсэн

Арга хэмжээг
хэрэгжүүлэх
нөөц, төсөв,
санхүүгийн эх
үүсвэр
тодорхой

Шалгуур
үзүүлэлт нь
тодорхой,
хэмжигдэхүйц

Судалгаа
шинжилгээнд
суурилсан

Мэдээллийн
үнэн зөв,
найдвартай
байдлыг
хангасан

Төрийн
үйлчилгээг
чанартай,
шуурхай, үр
дүнтэй
хэрэгжүүлэхэд
чиглэсэн

Хууль
тогтоомжид
нийцсэн

ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ
БОЛОВСРУУЛАХАД
БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Хүлээгдэж
байгаа
өөрчлөлтийг
илэрхийлсэн
тодорхой
зорилт, арга
хэмжээг
агуулсан

Зорилт, арга
хэмжээ нь
хоорондоо
үялдсан

Зорилт, арга
хэмжээг
хэрэгжүүлснээр
бий болох үр
дүнг
тодорхойлсон

Үр дүнг хэмжих
шалгуур
үзүүлэлтийг
тодорхойлсон

Шалгуур
үзүүлэлтийн
хүрэх түвшин
тухайн жилдээ
хэрэгжих
боломжтой

Тоон болон
чанарын утгаар
илэрхийлэгдсэн,
хэмжигдэхүйц

Шаардагдах
хөрөнгийн
хэмжээ,
санхүүжилтийн
эх үүсвэрийг
тусгасан



Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад ХДЖ-ын 5.1.4-т зааснаас гадна дараах баримт бичигт үндэслэнэ

Хуулиар олгосон
чиг үүргийг
хэрэгжүүлэх арга
хэмжээ

Албан хаагчдын
сургалтын
хөтөлбөр

Ажиллах нөхцөл,
нийгмийн
баталгааг хангах
хөтөлбөр



Шалгуур үзүүлэлтийг тодорхойлох

S	Тодорхой – хүссэн үр дүнд хүрэхийн төлөө	C	Тодорхой
M	Хэмжихүйц – хэмжиж болохуйц үр дүн, үр дагавар	R	Ач холбогдолтой
A	Биелүүлэхүйц – бодитой байх	E	Үр ашигтай
R	Ач холбогдолтой – тодорхойлсон хэрэгцээ шаардлагад нийцсэн	A	Зохистой
T	Цаг хугацаатай – хэрэгжүүлж болох	M	Хяналт тавихуйц



Суурь түвшнийг тодорхойлох

Суурь түвшин нь зорилт, арга хэмжээ эхлэх үеийн, эсхүл эхлэхээс өмнөх үеийн байдлын талаарх тоон болон чанарын мэдээлэл юм.

Ирээдүйн гүйцэтгэлийг хэмжих эхлэлийн цэг, эсвэл чиглүүлэгчээр суурь түвшинг хэрэглэнэ.



Зорилтот түвшинг тодорхойлох

Тодорхой хугацаанд ямар ахиц өөрчлөлтөд хүрч болох талаар үр дүнгийн зорилтот түвшинг тогтооно.

Зорилтот түвшин тогтоох нь гүйцэтгэлийн тогтолцоог бүрдүүлэх сүүлчийн алхам бөгөөд үр дүн, шалгуур үзүүлэлт, суурь түвшинд үндэслэнэ.



Жишээ : ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө

3. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

3.1. Төмөр замын тээврийн талаарх хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;

Арга хэмжээ: 3.1.1.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулах

Хэрэгжих хугацаа: I улирал, II улирал, III улирал, IV улирал

Шаардагдах хөрөнгө: Шаардагдахгүй

Суурь түвшин: Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл УИХ-д өргөн мэдүүлсэн.



Жишээ : ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө

Шалгуур үзүүлэлт: Хууль тогтоомжийн боловсруулах үе шат /Хууль тогтоомжийн тухай хууль/

Хүрэх түвшин: УИХ-ын дэд ажлын хэсэгт саналаа өгсөн байна.

I улирал: Ажлын хэсэг байгуулсан байна

II улирал: Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн байна

IV улирал: УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанд хэлэлцүүлсэн байна



Жишээ: ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын гүйцэтгэлийн ТӨЛӨВЛӨГӨӨ

2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ

2.2. Суурь бүтэц ашиглах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх болон суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

Арга хэмжээ: 2.2.1. Төмөр замын тээврийн үйлчилгээ, суурь бүтэц ашиглах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх болон суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

Хэрэгжих хугацаа: I улирал, II улирал, III улирал, IV улирал



Жишээ: ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Шаардагдах хөрөнгө: Шаардагдахгүй

Суурь түвшин: Хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл олгоно

Шалгуур үзүүлэлт: Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийн дагуу тавигдах шаардлага

Хүрэх түвшин: Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, жилийн эцсийн тайлан гарсан байна.

I улирал: 25%

II улирал: 50%

III улирал: 75%

IV улирал: 100%



Жишээ: ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө

1.Төмөр замын сүлжээ, суурь бүтцийг өргөжүүлэх чиглэлийг улсын эдийн засаг, нийгмийн чиг хандлага, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалахтай уялдуулан тогтоох

1.1.Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 681,6 км төмөр замыг барьж дуусган, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан, Зүүнбаян-Ханги чиглэлийн 1185,6 км төмөр замын төслийг эхлүүлнэ

Арга хэмжээ: 1.1.1.Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414,6 км төмөр замын барилгын ажлыг дуусгах

Хэрэгжих хугацаа: II улирал, III улирал, IV улирал



Жишээ: ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө

Шаардагдах хөрөнгө: 1,556,000,0 сая төгрөг /2021 онд 598,000,0 төг/
/Бүтээгдэхүүн хуваах гэрээ/

Суурь түвшин: Төмөр замын доод бүтэц 100 хувь, дээд бүтэц 35 хувь
хийгдсэн

Шалгуур үзүүлэлт: Барилгын ажлын явц, хувь

Хүрэх түвшин: Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьд хүргэнэ.

II улирал: 50%

III улирал: 90%

IV улирал: 100%



Жишээ: ГТХЗНТ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө

1. Төмөр замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.4, 14.3.5, 14.3.6, Төмөр замын техник ашиглалтын журмын 12.1.2, Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журмын 12.1, Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын 1.4, 1.6, 4.3, 6.1, 6.5, Төвийн дүрмийн 4.3.16, 4.3.17, 6.7.2.

1.1. Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг баталж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих зорилтын хүрээнд:

Арга хэмжээ: 1.1.1. Галт тэрэгний хөдөлгөөний 2021 оны зуны, 2021-2022 оны өвлийн цагийн хуваарийн нэгдсэн зурмаг боловсруулж батлах, гүйцэтгэлд хяналт тавих, тасалдалд дүн шинжилгээ хийх

Хэрэгжих хугацаа: I улирал, II улирал, III улирал, IV улирал



Жишээ: ГТХЗНТ-ийн гүйцэтгэлийн ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөв: Төсөв шаардагдахгүй

Шалгуур үзүүлэлт: Тайлангийн тоо 18

Суурь түвшин: Хэрэгжүүлж байна

Зорилтот түвшин:

I улирал: Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг тасалдлын 2020 оны XII болон IV улирлын, 2021 оны I, II сарын тайланг ЗТХЯ-нд танилцуулж, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийсэн тайланд тусгагдсан санал зөвлөмжийн биелэлтийг тооцно

II улирал: Зуны цагийн хуваарийн нэгдсэн зурмаг боловсруулж батална. Зурмаг тасалдлын III, IV, V сарын болон I улирлын тайланг ЗТХЯ-нд танилцуулна



Жишээ: ГТХЗНТ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө

III улирал: Зурмаг тасалдлын VI, VII, VIII сарын болон II улирлын тайланг ЗТХЯ-нд танилцуулна. Суурь бүтэц дэх 2020-2021 оны өвлийн хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд ашиглалтын ажлын чанарын болон тоон үзүүлэлтээр дүн шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргаж гүйцэтгэлийг сайжруулах албан даалгавар өгнө

IV улирал: 2021-2022 оны өвлийн цагийн хуваарийн нэгдсэн зурмаг боловсруулж батална. Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийсэн тайланд тусгагдсан санал зөвлөмжийн биелэлтийг тооцно. Зурмаг тасалдлын IX, X, XI сарын болон III улирлын тайланг ЗТХЯ-нд танилцуулна. Суурь бүтэц дэх хөдөлгөөний зуны зурмагийн гүйцэтгэлд ашиглалтын ажлын чанарын болон тоон үзүүлэлтээр дүн шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргаж гүйцэтгэлийг сайжруулах албан даалгавар өгнө

3.1.Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх зорилтын хүрээнд:

3.1.1.Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацааг сунгах, нөхөн олгох талаар санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан бүрдүүлж хөтлөх, баяжуулах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах үйл ажиллагааг эрх шилжүүлсний үндсэн дээр хэрэгжүүлэх


Шалгуур үзүүлэлт: ТЗТАБХЗОУАГОЖ-ын 4, 5, 6, 7 дугаар бүлэг болон тавигдах шаардлага

Суурь түвшин: Хэрэгжүүлж байна

Зорилтот түвшин: Гэрчилгээжүүлэлтийн баримт бичгийн иж бүрдлийг нягтлан шалгаж гэрчилгээжүүлэлтийн нөхцөл шаардлага хангаж буй эсэхийг холбогдох журмын хүрээнд хянан, санал дүгнэлт, шийдвэрийн төслийг ЗТХЯ-нд уламжлан



Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах





Иж бүрэн	Тайланд тусгагдсан асуудлыг зохих ёсоор зөв ойлгох, тайланд тавигдах шаардлагад нийцүүлэн хэрэгцээтэй мэдээллийг тусгасан, хавсаргасан байх
Алдаа мадаггүй	Үнэн бодитой, зөв зүйтэй илэрхийлэгдсэн байх, нэг алдаа илэрвэл тайлангийн үнэн бодитой эсэхэд эргэлзэхэд хүргэх, байгууллагад итгэх итгэлийг сулруулж, тайлангийн үр нөлөөг бууруулах эрсдэлтэй
Бодитой	Тайланг уншсан хүн өөрийн эрхгүй үнэмших байдлаар ямар нэгэн урьдчилсан байр суурьгүйгээр илэрхийлж чадвал тайланд итгэх итгэл мэдэгдэхүйц дээшилнэ



Итгэл үнэмшил төрүүлэхү йц	Гүйцэтгэлийн үр дүн, зорилтуудад хариулт болж чадахуйц, үр дүнг үнэмшилтэй илэрхийлсэн байх
Тодорхой	Тайланг уншиж, ойлгоход хялбар, аль болох тодорхой, энгийн үг хэллэгээр бичигдсэн байх, утга санааг шулуухан илтгэсэн, техникийн бус үг хэллэг ашиглах, товчилсон үгийг аль болох бага хэрэглэх
Товч	Хэлэх гэсэн зүйлээ бусдад хүргэхээс илүү урт байх ёсгүй. Хэт дэлгэрэнгүй мэдээлэл оруулах нь тайлангийн ач холбогдлыг бууруулах, гол санааг далдлах, хэрэглэгчдийг төөрөлдүүлэх, нэг зүйлийг дахин давтахгүй байх



Жишээ: Сайн төлөвлөлт, сайн хэрэгжилт

Арга хэмжээ: Шинэ төмөр замын төсөл, хөтөлбөр болон техникийн баримт бичигт тусгах санал дүгнэлт гаргах

Төсөв: Шаардлагагүй

Шалгуур үзүүлэлт: Боловсруулалтын явц, хувиар

Суурь түвшин: Хэрэгжүүлж байна

Хугацаа: Тухай бүр

Зорилтот түвшин: Санал дүгнэлт боловсруулж ЗТХЯ-нд танилцуулна.

Жишээ: Сайн төлөвлөлт, сайн хэрэгжилт



Хэрэгжилт: “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийг зохион байгуулах төсөлд тусгах саналыг 2021.01.14-ний 09, 2021.01.25-ны 31, Зүүнбаян-Тавантолгой” чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийг зохион байгуулах төсөлд тусгах саналыг 2021.01.25-ны 29, 2021.01.25-ны 30 дугаартай албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК, “УБТЗ” ХНН-т тус тус хүргүүлсэн.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын км, зуутын “Замын тэмдэг” байрлуулах, тооллыг эхлүүлэх талаарх саналыг “МТЗ” ТӨХК-д 2021.03.30-ны 125 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

“Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-т тусгах саналыг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад 2021.05.06-ны 171 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

“Богдхан төмөр зам” төслийг хэрэгжүүлснээр ачааны урсгал болон галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт орох өөрчлөлтийг урьдчилсан байдлаар тогтоох, төмөл ашиглалтад орсноор УБ хотын төвөөр өнгөрөх галт тэрэгний тооцоо судалгааг Улаанбаатар, Толгойт зэрэг өртөөний хоногийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулан гаргаж галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн төслийг боловсруулж ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т 2021.05.11-ний 175 дугаартай албан бичгээр танилцуулсан.

Тавантолгой-Зүүнбаян төслийн төмөр замд туршилтын галт тэрэг аялуулах /зүгшрүүлэх/ түр горимын төсөлд тусгах саналыг “МТЗ” ТӨХК-д 2021.08.19-ний 279 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.



Жишээ: Сул төлөвлөлт, сайн хэрэгжилт

Арга хэмжээ: ГТХЗНТ-ийн үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Төсөв: Шаардлагагүй

Шалгуур үзүүлэлт: ХШҮ-ний тайлангийн тоо 18

Суурь түвшин: Төвийн үнэлгээгээр 90.6 хувь

Хугацаа: I улирал, II улирал, III улирал, IV улирал

Зорилтот түвшин: Урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянан, мэдээлж төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж үнэлэлт өгнө



Жишээ: Сул төлөвлөлт, сайн хэрэгжилт

Хэрэгжилт: “ГТХЗНТ” УТҮГ-ын үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнд 14 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нийт 142 санал зөвлөмж бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ХШҮ-ний тайлан, дүгнэлт ил тод байх зарчмын хүрээнд эйбл системд байршуулж мэдээлсэн.



Жишээ: Сайн төлөвлөлт, хангалтгүй

ХЭРЭГЖИЛТ

Арга хэмжээ: Нийлүүлэлтийн сүлжээний RFID хэрэглээ-ачааны чингэлэг, ачааны чингэлгийг автоматаар тодорхойлон таних систем ISO 17363:2007, Мэдээллийн технологи, удирдлагын радио давтамжийг ялган тодорхойлох таних тэмдэг ISO/IEC 29160:2012 стандартыг орчуулан боловсруулж батлуулах

Төсөв: 6.0

Шалгуур үзүүлэлт: Боловсруулалтын явц, хувиар

Суурь түвшин: Орчуулж боловсруулсан

Хугацаа: I улирал

Зорилтот түвшин: ТЗДАБУЗСТХ-гоор хэлэлцүүлж үндэсний стандартаар батлуулна



Жишээ: Сайн төлөвлөлт, хангалтгүй хэрэгжилт

Хэрэгжилт: Мэдээллийн технологи, удирдлагын радио давтамжийг ялган тодорхойлох таних тэмдэг ISO/IEC 29160:2012 стандартыг ТЗДАБУЗСТХ-гоор хэлэлцүүлэхээр хурлын товыг хүлээж байна. Дэлхий нийтийн цар тахал Ковид-19-тэй холбогдуулан удаашралтай байна.



Жишээ: Сул төлөвлөлт, хангалтгүй хэрэгжилт

Арга хэмжээ: Олон Улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх үзэл баримтлалын баримт бичиг боловсруулах

Төсөв: Шаардлагагүй

Шалгуур үзүүлэлт: Боловсруулалтын явц, хувиар

Суурь түвшин: Шинээр хэрэгжүүлнэ

Хугацаа: I улирал, II улирал, III улирал, IV улирал

Зорилтот түвшин:

I улирал: Төмөр замын хамтын ажиллагааны байгууллага /ОСЖД/-тай хамтран ажиллах суурийг бэхжүүлнэ



Жишээ: Сул төлөвлөлт, хангалтгүй хэрэгжилт

II улирал: Хөрш орнуудын төмөр замын байгууллагуудтай холбоо тогтоож хамтран ажиллах суурийг бэхжүүлнэ

III улирал: Япон улсын Жет Коннект ХХК-тай хамтарсан ажлын хэсэг байгуулах хамтран ажиллана

IV улирал: Хилийн боомтын өртөөдтэй хамтарч ажиллах суурийг бэхжүүлнэ

Хэрэгжилт: Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллага (ОСЖД)-тай хамтран ажиллах, холбоо тогтоох зорилгоор ТЗХАБ-д 03 дугаар сард цахим шуудан илгээсэн.



Гүйцэтгэлийг үнэлэх арга зүй

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} * 100\%$$

Зорилт, арга хэмжээ хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол **90.0 хувь**

Зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол **70.0 хувь**



Гүйцэтгэлийг үнэлэх арга зүй

Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол **50.0 хувь**

Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол **30.0 хувь**

Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол **0 хувь**




Гүйцэтгэлийг үнэлэх арга зүй

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дээрх аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр дараах ангилалд шилжүүлэн тооцно:

“Үр дүнтэй” – зорилт, арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол **100 хувь**

“Тодорхой үр дүнд хүрсэн” – зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол **70-99 хүртэл хувь**



Гүйцэтгэлийг үнэлэх арга зүй

“Эрчимжүүлэх шаардлагатай” – зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол **31-69 хувь**

“Үр дүнгүй” – зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол **0-30 хувь**

Гүйцэтгэлийн тайланд тухайн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан нөхцлийг тодорхой тусгах бөгөөд мэдээллийн үнэн, зөв байдлыг холбогдох нэгж, албан тушаалтан хариуцна.